

# “УУЛ УУРХАЙ, БАЙГАЛЬ ОРЧНЫ САЛБАРЫН БОДЛОГО, ХУУЛЬ ТОГТООМЖ, ХЭРЭГЖИЛТ”

СУРГАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Ховд аймаг, Жаргалант  
2019 оны 6 дугаар сарын 26-27-ны өдрүүд



УУЛ УУРХАЙ  
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ



БАЙГАЛЬ  
ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР




СЕСМИМ  
ТӨСӨЛ  
МОНГОЛ УЛСЫН ОЛБОРИХ САЛБАРЫН  
МЕНЕЖМЕНТИЙГ БЭХЖҮҮЛЭХ ТӨСӨЛ

Сэдэв:

Уул уурхайн салбарын  
өнөөгийн байдал,  
цаашид авах арга хэмжээ

Г.ГАНХҮҮ,  
Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны  
Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод  
аудитын газрын дарга

УЛСЫН ИХ ХУРАЛ



Монгол Улсын тогтвортой хөгжил, эдийн засгийн өсөлтийг хангах зорилгоор УИХ-аас 2014 онд Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт төрөөс баримтлах бодлогын баримт бичгийг баталсан.



Засгийн газраас хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх, бизнесийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор эрх зүйн орчныг сайжруулахаар ажиллаж байна.

## МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ-2030

(УИХ-ын 2016 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн 19 дүгээр тогтоол)

### **2.1.3. Аж үйлдвэрийн салбар**

**Зорилт 1.** Аж үйлдвэрийг дэвшилтэт техник, технологи, инновацид суурилан хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх.

**Зорилт 3.** Химийн аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлж, гол нэр, төрлийн шатахууны хэрэгцээг олон улсын стандартад нийцсэн дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр бүрэн хангана.

**Зорилт 4.** Хар төмөрлөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, уул уурхай, барилга, дэд бүтцийн байгууламжийн үндсэн нэр төрлийн төмөр, ган хийцийн хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангана.

### **2.1.4. Эрдэс баялгийн салбар**

**Зорилт 1.** Геологийн салбарын хөгжлийг дэмжинэ.

**Зорилт 2.** Ил тод, хариуцлагатай олборлох үйлдвэрлэлийг төлөвшүүлж, уул уурхайн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.

## “ТӨРӨӨС ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРТ БАРИМТЛАХ БОДЛОГО” (2014–2025 он)

(УИХ-ын 2014 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 18 дугаар тогтоол)

1.1. “... хувийн хэвшилд түшиглэсэн, **ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, ойрын болон дунд хугацаанд эдийн засгийн тэнцвэртэй олон тулгуурт бүтцийг бий болгох ...**”

1.2. “... ашигт малтмалын хайгуул, олборлолт, боловсруулалтын чанарыг дээшлүүлэх, **нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, олон улсын зах зээлд өрсөлдөх чадварыг бэхжүүлэх...**”

## “ТӨРӨӨС АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО”

(УИХ-ын 2015 оны 06 сарын 19-ний өдрийн 62 дугаар тогтоол)

1.2. “... хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, **уул уурхайн олборлох үйлдвэрлэлээс мэдлэг, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгож, аж үйлдвэрийн бүтцийг төрөлжүүлэн, бүтээмжийг дээшлүүлэх ...**”

5.1.1. **I үе шат /2015–2020 он/:** үндэсний үйлдвэрлэлийг хамгаалж, үндсэн түүхий эдийг дотооддоо боловсруулж, техник, технологийг нутагшуулан экспортыг дэмжих, импортыг орлох аж үйлдвэрийн бодлогыг хэрэгжүүлнэ.

5.1.2. **II үе шат /2020–2025 он/:** экспорт давамгайлсан аж үйлдвэрийн бүтцийг бий болгож өндөр технологи, машин, тоног төхөөрөмж, химийн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

5.1.3. **III үе шат /2025–2030 он/:** мэдлэгт суурилсан аж үйлдвэрийг хөгжүүлж, үйлчилгээ болон технологийн экспортыг дэмжин хөгжүүлнэ.

## “МОНГОЛ УЛСЫН ТӨРӨӨС ЦАЦРАГ ИДЭВХТ АШИГТ МАЛТМАЛ БОЛОН ЦӨМИЙН ЭНЕРГИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО”

(УИХ-ын 2009 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 45 дугаар тогтоол)

1.1. “... нөөц баялгаа гүнзгийрүүлэн судлах, түүнийг энхийн зорилгоор олборлогч, боловсруулагч, экспортлогч тэргүүлэгч орны нэг болох, улмаар цөмийн энергийг эдийн засаг, нийгмийн салбарт өргөн хүрээнд ашиглах, хүний эрүүл мэндэд аюулгүй, экологийн хувьд цэвэр, байгаль орчинд ээлтэй технологиор цөмийн эрчим хүч үйлдвэрлэх ...”

1.3. “... цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн эрчим хүчийг энхийн зорилгоор ашиглах, цацраг идэвхт ашигт малтмалын нөөцийг өсгөх, олборлолт, боловсруулалтыг нэмэгдүүлэх ...”

## “ТӨРӨӨС ӨНДӨР ТЕХНОЛОГИЙН АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО”

(УИХ-ын 2010 оны 06 сарын 24-ний өдрийн 34 дүгээр тогтоол)

1.3. “... хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, уул уурхайн олборлох үйлдвэрлэлд түшиглэсэн эдийн засгаас тэргүүний, дэвшилтэт мэдлэг, технологид суурилсан мэдлэгийн эдийн засагт шилжүүлэх гарц, аж үйлдвэрийн төрөлжилтийг эрчимжүүлэн үндэсний баялгийг богино хугацаанд эрс нэмэгдүүлэх ...”

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

(УИХ-ын 2016 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн 45 дугаар тогтоол)

### Хоёр. Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлого

2.1. Монгол Улсын Үйлдвэржилтийн газрын зургийг гаргаж, хүнд аж үйлдвэрийн хөгжлийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

2.2. Монгол Улсад үйлдвэрлэсэн уул уурхайгаас бусад салбарын бүтээгдэхүүний 50-аас дээш хувийг экспортод гаргаж байгаа аж ахуйн нэгжийг татварын бодлогоор дэмжинэ.

2.3. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг хөрөнгийн зах зээлд бүртгүүлэх, арилжих, эргэлтэд оруулах замаар иргэдэд эзэмшүүлсэн 1,072 хувьцааг үнэ цэнэтэй болгоно.

2.4. Оюутолгой, Тавантолгой, Эрдэнэт зэрэг томоохон компаниудын үр ашгийг иргэн бүрд хүртээмжтэй байлгах бололцоог бүрдүүлнэ.

2.5. Томоохон төслийг хэрэгжүүлж байгаа аж ахуйн нэгжүүдэд олгох зээлийн хугацааг уртасгаж, хүүг бууруулах нөхцөлийг бүрдүүлнэ.

2.17. Шатахууны үнийг дэлхийн зах зээлийн үнэтэй уялдуулан үнийн дарамтыг бууруулна.

### Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ:

Геологи, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэх, уул уурхайн салбарын тогтвортой хөгжлийг хангах, олон улсын эрдсийн зах зээл дэх Монгол Улсын өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.

2.59. Монгол орны геологийн зураглал, ерөнхий эрэл, агаарын геофизик, геохими, гидрогеологи, геоэкологийн судалгааны ажлын хэмжээг нэмэгдүүлэх замаар уул уурхайн салбарын тогтвортой хөгжлийг дэмжинэ.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2016–2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

(УИХ-ын 2016 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн 45 дугаар тогтоол)

### Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ:

- 2.60. Олон улсын жишгийн дагуу Үндэсний геологийн алба, Үндэсний геомэдээллийн санг байгуулан, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулна.
- 2.61. Геологи, уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтыг татах эрх зүйн таатай орчинг бүрдүүлж, харилцан үр ашигтай төсөл, хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлнэ.
- 2.62. Уул уурхайн үйлдвэрлэл дэх төрийн оролцоог зохистой хэмжээнд байлгаж, Кадастрын бүртгэлийн системийг боловсронгуй болгож, тусгай зөвшөөрөл олгох үйлчилгээг хөнгөн шуурхай болгоно.
- 2.63. Газрын тосны болон уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын ажлыг эрчимжүүлж, нөөцийг өсгөнө.
- 2.64. “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын 3.1.2-т заасан иргэд бичил уурхайн салбарт хууль ёсны бүтцээр хоршиж ажиллах чиглэлийг хэрэгжүүлэн холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.
- 2.65. Уул уурхайн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлт боловсруулж, салбар хоорондын уялдааг сайжруулна.
- 2.66. Уул уурхайн судалгааны нэгж байгуулж, эрдэс баялгийн салбарт хөрөнгө оруулалтын таатай орчинг бий болгоно.
- 2.67. Хоёрдогч ашигт малтмал ашиглах эрх зүйн орчинг бий болгож, уурхайн нөхөн сэргээлт, хаалтыг олон улсын жишигт хүргэнэ.
- 2.68. “Алт-2” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг Монголбанкттай хамтран шийдвэрлэнэ.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2016–2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

(УИХ-ын 2016 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн 45 дугаар тогтоол)

### Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ:

- 2.69. Алтны олборлолтыг нэмэгдүүлж, бичил уурхай эрхлэгчдийн олборлосон алтыг худалдан авах эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
- 2.70. Газрын тосны олборлолтыг тогтвортой нэмэгдүүлэн, газрын тос боловсруулах үйлдвэр байгуулна.
- 2.71. Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлыг дэмжиж ажиллана.
- 2.72. Дархан, Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолбор байгуулах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 2.73. Нүүрс угаах, гүн боловсруулах үйлдвэр болон нүүрсний нийлэг хийн үйлдвэр байгуулахыг бодлогоор дэмжинэ.
- 2.74. Шингэрүүлсэн түлш, шатах тослох материалын үйлдвэр байгуулах ажлыг бодлогоор дэмжинэ.
- 2.75. Метал хийц, угсралтын үйлдвэрийг хөгжүүлнэ.

## “ГУРВАН ТУЛГУУРТ ХӨГЖЛИЙН БОДЛОГО”

(УИХ-ын 2018 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн 42 дугаар тогтоол)

### 2.2.2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт:

- Зорилт 4.** Монгол Улсын эдийн засгийн өндөр өсөлтийг хангах уул уурхайг хөгжүүлж, томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулан иргэдэд ногдол ашиг хуваарилах нөхцөлийг бүрдүүлэх;
- Зорилт 5.** Хариуцлагатай уул уурхай, хүнд үйлдвэрийг хөгжүүлэх;
- Зорилт 6.** Уул уурхайн хөгжлийг дэмжих тээвэр, дэд бүтцийг барьж байгуулах.

## **“АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ”, 2006 он**

1. 2018 оны Төсвийн тухай хуулиар Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд хайгуулын тусгай зөвшөөрлийг өргөдлөөр өгдөг байсныг **СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ**-аар өгдөг болгосон. Аймаг, нийслэлийн Засаг дарга, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн саналыг авна.

2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн нэмэлт өөрчлөлт)

2. “Ашигт малтмалын тухай” хуулийн 10.1.2 дахь заалтын 20.1, 24.2, 26.9-д заасан сонгон шалгаруулах журмыг Засгийн газрын эрх олгосноор Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаалаар батлана.

## **“ТӨРӨӨС ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРТ БАРИМТЛАХ БОДЛОГО” (2014-2025 он)**

(УИХ-ын 2014 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 18 дугаар тогтоол)

### **3.2.2. Геологийн судалгаа, хайгуулын ажлыг эрчимжүүлэх зорилтын хүрээнд:**

3.2.2.4. Улсын хэмжээний геоэкологийн нэгдсэн судалгааг эрчимжүүлж, тодорхой хот, аймаг болон сумдын хэмжээнд геоэкологийн төрөлжсөн судалгааг гүйцэтгэх;

### **3.3. Олборлох салбарын хүрээнд:**

3.3.5. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд төр, орон нутгийн зүгээс тавих хяналт, төлбөр, хураамж ногдуулалтыг хүнд суртал, давхардалгүй болгох;

### **3.5. Орон нутгийн хөгжлийг дэмжих, орон нутгийн иргэдийн эрх ашгийг хамгаалах хүрээнд:**

3.5.1. Тухайн нутаг дэвсгэрт уул уурхайн олборлолт эхлүүлэхийн өмнө хөрөнгө оруулагч, орон нутгийн иргэдийн хоорондын харилцан ойлголцох нөхцөлийг бүрдүүлэх, уул уурхайн төслийн нийгэм, эдийн засгийн ач холбогдлыг тайлбарлан таниулах ажилд орон нутгийн удирдлагын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх;

3.5.2. Уул уурхайн олборлолтын хугацаанд нийгмийн хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилгоор хөрөнгө оруулагч компани, нутгийн өөрөө удирдах байгууллагын хооронд орон нутгийг хөгжүүлэх гэрээг ил тод байх, оролцооны зарчмыг баримтлан байгуулах.

## Геологийн ажлууд:



**Цаашдын зорилт:** Геологийн судалгааг эрчимжүүлж, 2020 он гэхэд 1:50 000 зураглалын ажлыг нутаг дэвсгэрийн 45 хувьд хүргэх.

## 3,078 хүчинтэй тусгай зөвшөөрөл

2018 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар байна.

4.5% нийт нутаг дэвсгэрийн



1.0% нийт нутаг дэвсгэрийн



## Баталгаат нөөц, баялаг:

Ашигт малтмал	Хэмжих нэгж	Нөөц баялаг, 2017
 Зэс	сая тн	57
 Нүүрс	тэрбум тн	37.2
 Төмрийн хүдэр	тэрбум тн	1.2
 Алт	тн	2.5
 Цайр	сая тн	1.7
 Хайлуур жонш	сая тн	48.3
 Уран	мян.тн	197
 Газрын тос	сая тн	332.6

Монгол орны Зүүн болон Төвийн бүс харьцангуй сайн судлагдсан бөгөөд цаашид [ХАНГАЙН БОЛОН БАРУУН БҮСЭД ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ АЖЛЫГ ЭРЧИМЖҮҮЛСНЭЭР ТОМООХОН ОРДУУДЫГ ИЛРҮҮЛЭХ](#) боломжтой.

## Эрдэс бүтээгдэхүүний салбарын гол нэр төрлийн үйлдвэрлэл

Гол нэр төрлийн бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2014	2015	2016	2017	2018
Нүүрс	мян.тн	25,287.8	24,205.9	35,522.3	48,145.1	51,401.3
Газрын тос	мян.бар	7,405.3	8,769.3	8,249.8	7,624.1	6,388.6
Зэсийн баяжмал, металл агуулгаараа	мян.тн	1,080.4	1,334.7	1,445.1	1,317.6	1,310.8
Молибдений баяжмал, металл агуулгаараа	тн	4,054.0	5,207.0	5,174.4	5,759.6	5,486.1
Алт	кг	11,503.8	14,532.8	18,435.7	19,849.0	20,655.2
Хайлуур жонш	мян.тн	303.0	183.5	167.7	108.9	101.2
Хайлуур жоншны баяжмал	мян.тн	71.9	47.3	34.1	55.2	80.7
Төмрийн хүдэр	мян.тн	6,293.1	4,273.6	4,936.2	7,694.7	6,225.4
Цайрын баяжмал	мян.тн	93.2	89.6	100.2	82.7	87.9
Катодын зэс 99%	тн	6,992.4	14,989.5	15,009.6	14,689.0	14,174.6

## Уул уурхайн салбарын төсвийн орлогод эзлэх хувь

10.1  = 21%

ИХ НАЯД



## Эдийн засагт үзүүлэх нөлөөлөл



24%

ДОТООДЫН НИЙТ  
БҮТЭЭГДЭХҮҮН




72%

АЖ ҮЙЛДВЭРИЙН  
САЛБАР



75%

ГАДААДЫН ШУУД  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ



87%

ЭКСПОРТ

## Уул уурхайгаас Орон нутгийн хөгжлийн санд

2019 он  
143.9  
(тэрбум төгрөг)

↑  
2018 онгой  
харьцуулахад  
62%



2018 он  
88.6  
(тэрбум төгрөг)

## Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт

Нүүрс,  
35.8 сая тн буюу \$2.8B, 38.9%



Молибдены хүдэр, баяжмал,  
6.0 мян.тн буюу \$49.9M, 0.7%

Цайрын хүдэр, баяжмал,...

Хар тугалганы хүдэр, баяжмал,  
23.2 мян.тн буюу \$57.4M, 0.8%

Газрын тосны бүтээгдэхүүн,...

Алт, 3.4 тн буюу \$144.5M, 2.0%

Жоншны хүдэр, баяжмал,...

Төмрийн хүдэр, баяжмал,...

Зэсийн хүдэр, баяжмал,  
1.4 сая тн буюу \$2.0B, 28.1%

### Газрын тосны хайгуул, олборлолт:

Монгол Улсын хэмжээнд газрын тосны хайгуулын **33** талбай ялгаснаас **26**-н аж ахуйн нэгж Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулан газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс **3**-н талбайд газрын тосны олборлолт, ашиглалтын үйл ажиллагаа явагдаж байна.

### Газрын тосны нөөц:

Нөөцийн төрөл	Нөөц, сая тн
Баталгаат	332.64
Ашиглалтын баталгаат	43.2

### Шинээр ашиглах боломжтой газрын тосны орд, илрэл:

Талбай	Хөх нуур-ХVIII	Галба-ХI
Өрөмдсөн цооногын тоо	4	14
Тосны илэрцтэй цооногын тоо	2	13




## Олборлолт, экспорт, улсын төсөвт төвлөрүүлсэн орлого:




- 2017 онд **7.62** сая баррель (**1.03** сая тн) олборлож, **7.5** сая баррель (**1.02** сая тн) экспортлон Улсын төсвийн **198.3** тэрбум төгрөгийн төвлөрүүлсэн.
- 1998-2017 онд газрын тосны экспортын орлогоос Улсын төсөвт нийт **1** их наяд **285.3** тэрбум төгрөгийг төвлөрүүлээд байна.
- 2018 онд **8.1** сая баррель (**1.1** сая тн) газрын тос олборлож, экспортлон Улсын төсөвт **223** тэрбум төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөөд байна.

## Импортын хэмжээ, мян.тн:



## “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК:



Засгийн газрын 2017 оны 92 дугаар тогтоолоор “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийг байгуулав.

## Геологи, хайгуул:



2018

13.3  
(тэрбум төгрөг)


2019

24.6  
(тэрбум төгрөг)

## Алт цэвэршүүлэх үйлдвэр:

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн харьяанд “АЛТ ЦЭВЭРШҮҮЛЭХ” үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэх төрийн өмчит “Эрдэнэс алт ресурс” ХХК-ийг байгуулсан.

## Стратегийн ордуудын хил, зааг:



Нарийнсухайт, Тавантолгой, Шивээ-Овоо, Багануур, Цагаансуварга, Бүрэнхаан, Эрдэнэтийн-Овооны зэс-молибдений ордуудын талбайн хил, заагийг тодорхой болгов.

## “Эрдэнэс-Тавантолгой” ХК:



“Эрдэнэс Тавантолгой” ХК гадаад, дотоодын хөрөнгийн биржид хувьцаагаа гаргахаар ажиллаж байна.

## Монголбанканд тушаасан алтны хэмжээ:

22 ТН  
+

Гадаад валютын  
нөөц

\$897 сая

### Геологийн салбар

“ Геологи, эрдэс баялгийн мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах, хайгуулын тусгай зөвшөөрлийг олгох ажлыг хялбаршуулах, Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажилд зарцуулах хөрөнгийг нэмэгдүүлэх ”

### Газрын тосны салбар

“ Газрын тосны хайгуулын ажлыг эрчимжүүлж нөөцийг өсгөх, бүтээгдэхүүн хуваах гэрээнд тавих хяналтыг чангатгах, газрын тосны бүтээгдэхүүний хангамж, чанарын хяналтын тогтолцоог сайжруулах ”

### Уул уурхайн салбар

“ Ашигт малтмалын хууль бус олборлолтыг зогсоох, төрийн өмчит уул уурхайн компанийн засаглалыг сайжруулах, уул уурхайн дэд бүтэц дэх төр-хувийн хэвшлийн түншлэлийг нэмэгдүүлэх ”

### Хүнд үйлдвэрийн салбар

“ Хүнд үйлдвэрийн салбарын үйл ажиллагааг жигдрүүлэх, томоохон төслүүдийн хэрэгжилтийг хангах, төмөрлөг бүтээгдэхүүний хэрэглээг дотоодоос хангах ”

- Геологийн салбарт “Геомэдээллийн сан” болон “Газрын ховор элемент” хөтөлбөрийг боловсруулж батлуулах, ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой талбайн хэмжээг нэмэгдүүлэх, газрын хэвлийн судалгаа, ашиглалтын үйл ажиллагааны зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлд ажиллана.
- Уул уурхайн салбарт Эрдэс баялгийн салбарын багц хуулийн төсөл болон Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг УИХ-аар хэлэлцүүлэн батлуулах, бичил уурхайгаар ашигт малтмал олборлохтой холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.
- Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын хүрээнд “Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хууль”-ийн төслийг боловсруулах Ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.
- Хүнд үйлдвэрийн эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр “Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн төслийг УИХ-аар хэлэлцүүлэн батлуулах, хүнд аж үйлдвэрийн “Хөгжлийн хөтөлбөр”-ийг Засгийн газраар батлуулахаар ажиллаж байна.
- Тавантолгойн ордын дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн хувьцааны тодорхой хувийг олон улсад нээлттэй арилжаалах, тусгай зөвшөөрөл эзэмшигч болон нутгийн захиргааны байгууллага хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх.

- Хайгуулын тусгай зөвшөөрлийг өргөдлөөр олгох асуудлыг дахин сэргээх;
- Орон нутагт тулгардаг хүндрэлтэй асуудлуудыг нэгдсэн бодлогоор шийдвэрлэх, нэгдмэл ойлголтод хүрэх, орон нутагт салбарын асуудал хариуцсан нэгжийг байгуулах;
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарын олон нийтийн боловсролыг дээшлүүлэх чиглэлд ажиллах;
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дэргэд сургалт, судалгаа шинжилгээний байгууллага байгуулах;
- Уул уурхайн бүтээгдэхүүнийг гүн боловсруулах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх асуудлыг бодлогоор дэмжих;
- Томоохон төслүүдийг иж бүрнээр нь хэрэгжүүлж үр өгөөжийг нэмэгдүүлэх;
- Салбарт шаардлагатай цахилгаан эрчим хүч, авто зам, төмөр зам, усан хангамжийн дэд бүтцийг бүрдүүлэх;



Монгол Улс, Улаанбаатар хот, Нэгдсэн Үндэстний гудамж 5/2, Засгийн газрын II байр



976-(51)-263023



976-(11)-318169



[erdenebaty@gmail.com](mailto:erdenebaty@gmail.com)



[www.mmhi.gov.mn](http://www.mmhi.gov.mn)

**АНХААРАЛ ТАВЬСАНД  
БАЯРЛАЛАА**